



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 5/02

Ховд

Б.Түвшинсайханыг ажилд  
томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 60.2, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3, 56.6 дахь заалт, Улсын Их Хурлын 2007 оны 73 дугаар “Улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолын 1 дэх заалт, Буянт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуралдааны 4/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг нь Авлигатай тэмцэх газрын 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 05/844 тоот албан бичгээр хянагдаж ирсэн Бямбадоржийн Түвшинсайханыг 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн Буянт сумын Засаг даргаар томилсугай.

2. Б.Түвшинсайханд Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралтаар батлагдсан “Улс төрийн албан тушаал эрхэлдэг зарим албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээ”-ний дагуу 943539 төгрөг (есөн зуун дөчин гурван мянга таван зуун гучин ес)-өөр цалинжуулж, албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийг албан тушаалын сарын үндсэн цалингийн 30 хувиар тооцон, холбогдох бусад нэмэгдлүүдийг сар бүр бодож олгохыг Буянт сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Д.Болортуяа)-д зөвшөөрсүгэй.

3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдол бүрт тайлбар, мэдүүлэг гаргаж ажиллахыг Б.Түвшинсайханд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ